



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/40

Бодь

Олон нийтийг хамруулан зохион байгуулах
арга хэмжээнүүдийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/09 дугаар захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн 02 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт (Шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруудах) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтны уралдаан тэмцээнийг 2022 оны 06 дугаар сар хүртэл хориглосугай.

2. Сумын хэмжээнд коронавирусын халдварын тархалт өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан олон нийтийг хамруулан зохион байгуулах арга хэмжээнүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглож, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсүгэй.


3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд зохих журмын дагуу хяналт тавьж нийтийг хамарсан арга хэмжээг дээрх хугацаанд бүрэн зогсоохыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа), Хэсгийн төлөөлөгч (М.Цэнд-Аюуш) нарт, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг Эрүүл мэндийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэнхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

5. Сумын Засаг даргын 2022 оны А/06 дугаарын захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ



642201063